

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕРИЙН 2009 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

1.1. АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллагын бүтээгдэхүүн	Төрийн албан хаагчийн тухайн жилд гүйцэтгэх ажил, үйлчилгээ	Ажил, үйлчилгээний шалгуур үзүүлэлт (хүрэх түвшин)	Оноо
1	2	3	4

а. НИЙТ (Тусгай захиалгат ажил, үйлчигээнээс бусад) АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

1.1: Эдийн засгийн хөгжлийн бодлого, зохицуулалт

<p>Бүтээгдэхүүн 1.1.1: 1. Эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, хандлага, чиглэлийг боловсруулах</p>	<p>а) Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадны бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээг мэдээнд хамруулна.</p>	<p>Аймгийн ДНБ-ий хэмжээг бүрэн тооцох зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадны бүртгэлтэй 294 ААН-ийн 63-ыг нь өөрийн аймгийн нэр дээр шилжүүлэн бүртгэж, 2009 онд “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтээр байгуулагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний цэг салбарын бүтээгдэхүүнийг мэдээлэлд хамруулав.</p> <p>2009 онд Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар хотын харьяа Цаг клуб, Восток энерго, Заамарын их алт, НЬЮ нарри зэрэг 26 ААН ыг салбараар бүртгэж татварт хамрууллаа.</p> <p>2009 оны байдлаар 118 аж ахуйн нэгжийг шинээр татварын албанд бүртгэснээс ХХК-75, ЗБН-5, төсөвт-2, ТББ-8, Хоршоо-1, салбар-26, ОНБ-1 байна. Оны эхэнд татварын албанд 1180 аж ахуйн нэгж, байгууллага албан ёсоор бүртгэлтэй байснаас 44 аж ахуйн нэгж татан буугдаж, шинээр 74 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдэж, оны эцэст 1254 аж ахуйн нэгж албан ёсоор бүртгэлтэй байна. Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын алба, ГХБХБГазрын хамтарсан ажлын хэсэг Баян, Эрдэнэ, Архуст сумдад ажиллан 8 аж ахуйн нэгжийг аймгийн татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлэх тухай зөвлөмж, зааварчилгаа өгч ажиллаа. Татварын бааз өмнөх оноос 6,2 хувь буюу 74 татвар төлөгч аж ахуйн нэгжээр нэмэгдлээ.</p>	
	<p>б) Сумдын Засаг даргын орлогч нарт “Дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тооцох аргачилал” сэдэвт сургалт зохион байгуулна.</p>	<p>Сумдын Засаг даргын орлогч нарт “Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг тооцох аргачлал” сэдэвт сургалтыг 03-р сард зохион байгуулж гарын авлага, товхимолоор хангав.</p>	
	<p>в) Аймгийн эдийн засаг нийгмийн үзүүлэлтүүдийн мэдээллийн санг өргөжүүлэн баяжуулж, түүнийг төлөвлөлт удирдлага, хяналтын хэрэглүүр болгож, иргэдэд цахим хэлбэрээр мэдээлж байна.</p>	<p>Аймгийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтийн судалгааг холбогдох салбаруудын хүрээнд 21 үзүүлэлтээр гарган 27 сумдаас судалгааг нэгтгэн авч, аймгийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтийн</p> <ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн • ААН-ийн дэлгэрэнгүй судалгаа (бүртгэлтэй ААН, гадаадын хөрөнгө оруулалттай ААН, гадны бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН) 	

		<ul style="list-style-type: none"> • Ашигт малтмалын нөөц • Ой модны нөөц • Ан амьтны нөөц • Автотээврийн хэсэгсэл • Газрын нөөц • Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн • Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, үйлдвэрлэлийн судалгаа • Барилга, байгууламж • Орон сууц • Нар, салхины эх үүсвэр • Худаг усан сангийн судалгаа • Интернет ашиглалт • Үүрэн телефон хэрэглэгчдийн судалгаа • Халаалтын зуухны судалгаа • Өрхийн амжиргаа тодорхойлох • Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл • Банкны зээлийн багцын судалгаа • Банкны хадгаламж, зээлийн хүү, хугацааны шинжилгээ <p>зэрэг 21 төрлийн дэлгэрэнгүй судалгааг 27 сумыг хамруулан хийж мэдээллийг нэгтгэсэн. Сумдаас ирсэн мэдээллийг статистикийн мэдээ болон холбогдох мэргэжилтнүүдийн судалгаатай уялдуулан харьцуулалт хийж баяжуулах ажил хийгдэж байна. Дээрх судалгааг үндэслэн сум, бүс, аймгийн хэмжээний эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээллийн санг бүрдүүлээд байна.</p>	
	<p>г) Үр ашиггүй ажиллаж байгаа болон тухайн онд хүрэх зорилтот түвшингийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг жил бүр бууруулж байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн удирдлага менежментийг сайжруулна.</p>	<p>Орон нутгийн өмчит ААН, Байгууллагуудын 2008 оны санхүү, үйл ажиллагааны дүнд хяналт үнэлгээ хийж, гэрээний биелэлтийг дүгнэн, 2009 оны зорилтын санал, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг хянан аймгийн ИТХТэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнасан.</p> <p>Зорилтот түвшингийн үзүүлэлтийг хангаж чадаагүй 60 хувь буюу 3 үнэлгээ авсан Жаргалант сумын “Томоко” ОНӨҮГ-ын удирдлага менежментийг сайжруулахаар, сонгон шалгаруулалтын журмыг аймгийн Засаг даргын 211 тоот захирамжаар батлуулан, зар явуулсан боловч нэг этгээд оролцохоор хүсэлт ирүүлснээр шалгаруулалт явагдаагүй хүчингүй болсон.</p> <p>Борнуур, Зуунмод сумын Хүлэмжийн хотхонуудын үйл ажиллагааг түрээсийн гэрээгээр гүйцэтгүүлэхээр гэрээг шинэчлэн байгуулж, түрээсийн төлбөрийг тогтоон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаа.</p> <p>Япон улсын ЖАИКА, Тоттори муж, Төв аймгийн найрамдал нийгэмлэгийн 3 талт уулзалт “Томоко” ОНӨҮГ-ыг орон нутагт ХХААЖДҮГ-т шилжүүлээд байна. Тайлант хугацааны болон урд онуудын худалдан борлогдоогүй болон</p>	

		тайлант хугацааны шийдвэртэй хөрөнгийг худалдан борлуулж аймгийн хөрөнгө төвлөрүүлэх дансанд 20,9 сая төгрөг, ногдол ашиг 6,6 сая төгрөг, хүүгийн орлого 23,4 сая төгрөг, өмч хувьчлалаар 100,0 сая төгрөг төвлөрүүлсэн дүнтэй байна.	
	е) Сумын өмчийн харилцааг төлөвшүүлэн, мэргэжил арга зүйгээр хангаж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	Сумын Засаг дарга болон сумын өмчийн төлөөлөгч /Засаг даргын орлогч/-ийн сургалт семинараар сумын өмчийн харилцаа, эрх зүйн зохицуулалт сэдвээр семинар, зөвлөгөө өгч, сумын өмчийн харилцааг зохицуулахад шаардлагатай журам, заавар, үлгэрчилсэн загваруудаар гарын авлага бэлтгэн өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллав. Орон нутгийн өмчийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч “Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулах журам”, “Сумын өмчийн харилцааг зохицуулах үлгэрчилсэн журам” болон аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар батлагдсан 5 журам, 1 чиглэлийг нэгтгэн цэгцлэж, өөрчилж шинэчлэн боловсронгуй болгон аймгийн ИТХ-ын 4-р хуралдааны 6-р тогтоолоор “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн хэлэлцүүлэн батлуулсан. Шинэчилсэн журам болон өмчийн харилцааны холбогдолтой үлгэрчилсэн загвар, маягт аргачлалаар гарын авлага бэлтгэн сумын ИТХ, Засаг дарга, өмчийн төлөөлөгчид нэг нэг хувь болон аймгийн харъяа орон нутгийн өмчит бүх хуулийн этгээдүүдэд зөвлөмжийн хамт хүргүүлж арга зүйгээр ханган ажиллаа.	
<u>Бүтээгдэхүүн 1.1.2:</u> Төсөв, санхүүгийн бодлого, зохицуулалт	а)Төсвийн байгууллагуудын шатхууны хэрэглээ, түлш халаалтын зардлын судлагааг гарган шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Сумдын ЗДТГазруудын түлш халаалтын зардлын сүүлийн 3 жилийн судалгааг гарган харьцуулалт хийж үзэхэд 2009 оны төсвөөр зардлын хэмжээ урьд оныхоос 23.4 хувиар буурсан байна. Орон нутгийн төсвийн байгууллагуудын халаалтын зардлын судалгааг -Төвлөрсөн халаалтын системтэй -Тусгай халаалттай гэсэн ангиллаар зардлын судалгааг гаргав. Аймгийн Засаг даргын 573 тоот захирамжаар орон нутгийн төсвийн байгууллагуудад үүссэн өрийг барагдуулахад зориулж 103 сая төгрөгийг хуваарилан санхүүжүүлээ. Түлш халаалтын зардлын хувьд аймгийн Засаг даргын захирамжаар халаалтын үргэлжлэх хугацааг 8 сар байхаар тогтоож, 2010 оны төсвийн төсөлд тусган, зардлыг батлууллаа. Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын ажилтнуудын албан ажил гүйцэтгэхээр тухайн жилд явах нийт км-ыг тогтоож, сумын газар нутгийн хэмжээ, байршлын итгэлцлүүрээр нэмэгдүүлэх, багийн үйл ажиллагаанд зарцуулах шатахууны хэмжээг, хөдөөгийн баг, төвийн баг гэж ялгавартай тогтоон төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлж байхаар Шатахууны төлөвлөлтийн жишиг норматив тогтоон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 122 тоот тогтоолоор батлуулж, 2010 оны төсвийн зарлагын төлөвлөгөөнд мөрдөж ажиллав.	

	<p>б)Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2009 оны “Монгол улсын төсвийн орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний ангиллыг батлах тухай” 99 тоот тогтоолыг сум, байгууллагын дарга, санхүүгийн ажилтнуудад хүргүүлэв. Аймгийн 2010 оны төсвийн төсөл, 2011-2012 оны төсвийн төсөөллийг сум, төсөвт байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн, хөтөлбөрт суурилсан төсвийн зарлагын төлөвлөгөө, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, төсвийн зарлагын хязгаараас давсан саналын тооцоог боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, хуулийн хугацаанд Сангийн яаманд хянуулсан.</p> <p>Аймгийн 2010 оны төсвийн орлого 6327.4 сая төгрөг, төсвийн зарлага 5828.3 сая төгрөг байхаар төсвийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, хурлын ажлын хэсэг, АУДИТ-ын дүгнэлтийг тусган, аймгийн ИТХ-ын 6-р хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.</p>	
	<p>в) Төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулан төсвийн гүйцэтгэлийг аудитын байгууллагаар баталгаажуулан ажиллана.</p>	<p>Аймгийн Орон нутгийн төсвийн 2008 оны нэгдсэн санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраар санхүүгийн тайлангийн аудит хийлгүүлж, дүнг ИТХ-ын хуралдаанд оруулан хэлэлцүүлж, 2008 оны төсвийн нийт орлогыг 8038606.3 мянган төгрөг, зарлагыг 7784305.9 мянган төгрөгөөр тус тус батламжлуулсан.</p>	
	<p>г) Аймгийн төсвийн гүйцэтгэлийг улирал бүр ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж дүнг ИТХуралд тайлагнана.</p>	<p>2009 оны 1, 2, 3–р улирлын орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, ажиллаа. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын сар бүрийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүлээн авч нэгтэн Сангийн яам, статистикийн хэлтэст дамжуулж ажиллаа.</p>	
	<p>д)Төсвийн он дамжсан өр, авлагыг бууруулж, шинээр өр, авлага үүсгэхгүй ажиллана.</p>	<p>2009 оны 12-р сард орон нутгийн төсвийн байгууллагуудын өрийг барагдуулахаар Засаг даргын 573 тоот захирамжаар 103 сая төгрөгийг сумд болон төсөвт байгууллагуудад хуваарилан олгож өрийг барагдууллаа.</p> <p>БСШУЯ-ны төсвийн байгууллагуудад 321.0 сая төг, ЭМЯ-ны төсвийн байгууллагуудад 69.0 сая төгрөгийн санхүүжилтийг өрийг барагдуулахад зориулж 11, 12-р сарын санхүүжилтэд олгосон. Дээрхи арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2009 оны жилийн эцэст төсвийн нийт өр 55493,8 мян төгрөг, авлага 85556,2 мян төгрөг болсон байгаа нь оны эхний дүнгээс өр 174094,4 мян төгрөг буюу 75,8 хувиар, авлага 27922,7 мян төгрөг буюу 24,6 хувиар буурсан байна.</p>	
	<p>е)Аймгийн нутаг дэвсгэр дээр уул уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөх нөөцийн төлбөрийн тодорхой хувийг</p>	<p>2009 оны жилийн эцсийн байдлаар Алтнаас бусад нөөцийн төлбөрөөр сумын төсөвт 87412,5 мянган төгрөг, 87,2 хувь, аймгийн төсөвт 174824,9 мянган төгрөг төвлөрүүлсэн 87,2 хувь, улсын төсөвт 611887,4 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 70,1 хувьтай байна. Алтны нөөцийн төлбөрөөр сумын төсөвт 364236,0 мян төг, аймгийн төсөвт 728471,9 мян төг тус тус төвлөрүүлсэн. 2009 онд “Алтан-Дорнод” ХХК нь тодорхой шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулаагүйгээс алтны нөөцийн төлбөр 2,0 тэр бум</p>	

	аймаг суманд төвлөрүүлж, татварт бүрэн хамруулна.	төгрөгөөр тасарсан бөгөөд үүнийг хасч тооцвол орлогын төлөвлөгөөний биелэлт 134 хувьтай байна.	
	ё)Татварын он дамжсан өр, дутуу төлөлтийг хураан барагдуулна.	2008 оны жилийн эцсийн байдлаар татварын байцаагч нэг бүртэй татвар төлөгч бүрээр татварын өрийн тулгалт хийн хэлтсийн даргаар батлуулж 1526270,8 мян төгрөгийн татварын өр баталгаажсан. Үүнээс Татварын өршөөлийн хуульд 553704,0 мян төгрөгийн татварын өр хамрагдаж хүчингүй болгосон. 92058.2 мян төгрөг ШШГАлбанд шилжүүлсэн. Үлдэж байгаа 880458.6 мян төгрөгийн татварын өрийг татварын алба барагдуулахаас 2009 онд 680795.5 мян төгрөгийн өр барагдуулсан нь 77.3 хувь байна. Стандарт түвшингээр 723696,0 мян төгрөг барагдуулахаас 680795.5 мян төгрөг барагдуулсан байгаа нь 94.0 хувь болж стандарт түвшинг хангаж байна.	
Бүтээгдэхүүн 1.1.3: Үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, зохицуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	а)Бүсийн тулгуур төв Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мөрдөн, байшин хоорондын зай, ногоон байгууламж, спорт тоглоомын талбай байгуулах асуудлыг барилгын норм дүрмийн дагуу шийдвэрлэнэ	Зуунмод хотын “Хуульчдын хотхон”, “Хөгжил хотхон”, “134 айлын амины орон сууцны хороолол”, 200 айлын орон сууцны хороолол зэрэг барилга орон сууц төвлөрөн баригдах газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллаа. 1000 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн ажлыг “Инжежер геодези” ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2010 онд аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Шинээр барилга байгууламжийн зураг хийхдээ байшин хоорондын зай, ногоон байгууламж, спорт тоглоомын талбай, авто замын зогсоолын асуудлыг барилгын норм дүрмийн дагуу тусгаж өгсөн. 2009 онд шинээр баригдсан Боловсрол соёлын газрын контор, Халдвартын эмнэлгийн барилга, Эрдэнэ МСҮТ-ийн дотуур байр, Спорт цогцолборыг автозамын зогсоолтой, хашаа, гадны тохижилттойгоор төлөвлөж гүйцэтгүүллээ.	
	б) Жаргалант, Эрдэнэсант сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орчин үеийн хот байгуулалтын бодлоготой уялдуулан боловсруулж батлуулна.	Жаргалант, Эрдэнэсант сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах тендерийг 2009 оны 11 сард зарлахад Жаргалант сумын төлөвлөгөөг Инженер геодези зураг зүйн газар 22.0 сая төгрөгөөр, Эрдэнэсант сумын төлөвлөгөөг Нарт дизайн ХХК 19.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч ажлаа эхлээд байна.	
	в) Эрдэсжилт, хатуулаг ихтэй, ундны усны шаардлага хангахгүй байгаа Баянхангай, Аргалант, Жаргалант, Цээл, Угтаал, Сүмбэр, Баян-өнжүүл, Сэргэлэн сумдад ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах арга хэмжээг авч хүн амыг стандартын шаардлага хангасан	Ус зөөлрүүлэх төхөөрөмжийн танилцуулга, суурилуулах зураг төсвийг стандартын дагуу хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг “Зууны мэдээ” сонинд зарлан тендерийг зарлаж дүгнэлээ. Тендерт ШУТИС-ийн Усны нөөцийн нэгдсэн менежментийн сургалт судалгааны төв, “Мөнхийн үргэлжлэл” ХХК шалгаран Усны нөөцийн нэгдсэн менежментийн сургалт судалгааны төв Сэргэлэн, Баянхангай, Аргалант, Баян-Өнжүүл сумдад, “Мөнхийн үргэлжлэл” ХХК нь Жаргалант, Сүмбэр, Угтаал, Цээл сумдад ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулан гэрээт хугацаанд нь ашиглалтанд	

<p>усаар хангана.</p> <p>г) Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор “Үйлдвэрлэл хөгжүүлэх сан” байгуулж ажиллана.</p>	<p>хүлээлгэн өглөө.</p> <p>МУ-ын ЗГ-аас 2008 оны 62 тоот тогтоолоор 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил” болгосон. Жилийн ажлын хүрээнд хөнгөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Энэ ажлыг зохион байгуулж хяналт тавих дэд комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журмыг баталсан. Дэд комисс 5 удаа хуралдаж сумдаас ирсэн 329 төслийг хэлэлцэж 164 төсөлд 1093.8 сая төгрөгийн зээл олгож, зээлийн олголт 103.8%-тай байна. Нийт 1093.2 сая төгрөгийн зээлийн 65.3% буюу 714 сая төгрөгийг боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлийг дэмжихээр олгосон байна.</p> <p>2009 оны 03-р сард зохион байгуулсан сумдын Засаг даргын орлогч нарын сургалтаар “Сум бүрт хөгжлийн урт хугацааны хөтөлбөр” боловсруулж түүнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх үүрэг даалгавар өгсөн.</p> <p>Сум бүрт 17 сая төгрөг, Зуунмод суманд 98 сая төгрөг, нийт 540 сая төгрөгийн эх үүсвэртэй “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан” байгуулж, батлагдсан журмын дагуу боловсруулж зээл олгож байна.</p>	
<p>д) Худалдаа үйлчилгээний таатай орчинг бий болгоход дэмжлэг үзүүлэн хэрэглэгчээ дээдэлсэн үйлчилгээг бий болгоно.</p>	<p>Жижиг бизнес эрхлэгчдэд банк банк бус санхүүгийн байгууллагаас 2293 зээлдэгчид 3.9 тэрбум төгрөгийн зээл олгосон. ЖДҮ-ийг дэмжих сангаас үйлчилгээний чиглэлийн 23 төсөлд 133 сая төгрөгийн зээл олгосноос 8 сумын 21 оёдлын төсөлд 118 сая төгрөг ахйн үйлчилгээний 2 төсөлд 15.0 сая төгрөгийн зээл олгож үйл ажиллагаа нь эхлээд байна.</p> <p>2009 онд гутал болон гар утасны засварчин, тогооч, худалдагч, нярав нарын сургалтыг зохион байгуулж нийтдээ 17 сумын 187 иргэд хамрагдлаа.</p> <p>МХГ, ХЭАХН-тэй хамтран 21 суманд 352 худалдаа, үйлчилгээний цэг салбарт үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг засуулж үүрэг даалгавар өгч холбогдох арга хэмжээ авлаа. Худалдаа үйлчилгээний стандарт дундажаар 78.9%-тай байна.</p>	
<p>е) Төсөвт байгууллага болон иргэдийн хэрэгцээг өөрийн аймагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах бодлого баримталж ажиллана.</p>	<p>Аймгийн ИТХ-ын VI хуралдааны 04 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Үдийн цай” хөтөлбөрийг орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч нартай гэрээ байгуулан аймгийн хэмжээнд 520 гаруй сая төгрөгийн бүтээгдэхүүн хэрэглэхээс 360 гаруй сая төгрөгийн бүтээгдэхүүнийг орон нутгаас хангаж ажиллаж байна. “Үдийн цай хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар БСГ-ын даргын мэдээллийг хэлэлцэн Засаг даргын захирамж гарган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгээр төсөвт байгууллага болон иргэдийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг сумынхаа үйлдвэрлэл эрхлэгч нарын бүтээгдэхүүнээр хангах ажил зохион байгуулж байгаа байдалтай танилцахад бүх сумдын төсөвт байгууллагууд талх нарийн боов, мах, сүүний хэрэгцээг гэрээний үндсэн дээр иргэд, ААН-ээсээ хангах ажил тогтмолжсон байна.</p>	

	<p>ё)Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Махны үйлдвэрийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж, 431.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Мот-металл” ХХК шалгарч, гэрээ байгуулав.Санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан 2009 онд 300.0 сая төгрөг шийдвэрлэгдэж, барилгын суурийн ажил хийгдэж, ханын сэндвич материалыг БНХАУ-д захиалсан. 2010 онд хийгдэж ашиглалтанд орно. Махны үйлдвэрийн ашиглалтын өмнөх захиргааны даргыг томилж, Чех улсаас уг үйлдвэрт нийлүүлж буй 3 чингэлэг тоног төхөөрөмжийг хүлээн аваад байна.</p>	
	<p>ж)“Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>Аймгийн нийт сумд “Нэг баг-нэг бүтээгдэхүүн”, багт “Нэг өрх-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж сумынхаа шилдэг бүтээгдэхүүнийг тодруулж дүн мэдээг аймгийн “Нэг сум-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах үеэр ирүүлсэн юм. Сумдын ирүүлсэн мэдээ тайлангаас үзэхэд Дэлгэрхаан, Баян, Борнуур, Заамар, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баянжаргалан сумд бусад сумдаас илүү сайн зохион байгуулсан байна. Нийт 97 багийн 1500 гаруй бүтээгдэхүүн оролцож сум баг өөрийн брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулсан. Аймгийн хэмжээнд 2009 оны 10-р сарын 26-нд “Нэг сум-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 27 сумын 356 ААН, иргэд 672 нэрийн бүтээгдэхүүнээр оролцож 12.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. 2009 оны шилдэг бүтээгдэхүүнийг 5-н номинацаар шалгарууллаа. Энэ шалгаруулалтанд 14 сумын 16 бүтээгдэхүүн шалгарч цом, батламжаар шагнагдлаа. Аймгийн дүнгээр нийтдээ 58 шилдэг бүтээгдэхүүнтэй болсон. Төвийн бүсийн аймгуудийн “Төвийн бүсийн түншлэл-Дархан 2009” үзэсгэлэн худалдаанд оролцож Баяндэлгэр сумын “Эсгий эдлэл, эсгий гутлын бүлгийн памбагар цагаан” эсгий гутал бүсийн брэндээр, Зуунмод сумын Т.Батсайханы арьсан гутал, Алтанбулаг сумын “Лигийн-Ухаа” бяслаг, Баянцогт сумын “Могол ноос” ХХК-ны ноосон эдлэл бүсийн шилдэг бүтээгдэхүүнээр тус тус шалгарлаа.</p>	
	<p>з)Сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулна.</p>	<p>“Жишиг” төвийг Эрдэнэсант, Баянцагаан, Борнуур, Батсүмбэр 4 суманд байгуулахаар төлөвлөснөөс 2009 онд Борнуур сум 140.0 гаруй сая төгрөг, Эрдэнэсант, Өндөрширээт сум 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээний төвийн байрыг засварлаж үйл ажиллагааг тогтмолжуулсан. Дэлгэрхаан суманд ахуйн үйлчилгээний төвийн байрыг засварлан үйл ажиллагаа явуулж байна. Батсүмбэр, Баянцагаан сумдад ахуйн үйлчилгээний чиглэлээр банк, банк бус санхүүгийн байгууллагаас 6.5 төгрөгийн зээл олгосон байна.</p>	
	<p>и)Үйлдвэр технологийн парк барьж байгуулахыг дэмжиж ажиллана</p>	<p>Зуунмод сумын үйлдвэр технологийн холимог парк байгуулах эдийн засгийн тооцоо, мастер төлөвлөгөө хийхэд туслах зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 54 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан холбогдох судалгаа тооцоогоор хангаж ажиллав. Засгийн газраас томилогдсон Төслийн баг Зуунмод сумын үйлдвэрлэл</p>	

		<p>технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, мастер төлөвлөгөөг боловсруулан гаргаад байна.</p> <p>ҮТП 3 үе шаттай хэрэгжих бөгөөд 1-р үе шат буюу 2009-2011 төслийн бэлтгэл хангагдана.</p> <p>2-р үе шатанд 2012-2015 онд эхний үйлдвэрүүд баригдана.</p> <p>3-р үе шатанд 2016-2021 онд үйлдвэрүүд эцэслэн дуусна.</p> <p>Энэ төслийн хүрээнд 6 чиглэлийн 15 үйдвэр баригдах юм. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Мах болосруулах үйлдвэр -Хүнсний ногоо боловсруулах үйлдвэр -Талх, нарийн боовны үйлдвэр -120.0 мянган ширхэг сүлжмэл эдлэл үйлдвэрлэх сүлжмэлийн үйлдвэр -Өндөр техноглийн үйлдвэр -Барилгын материалын үйлдвэр -Аялал жуулчлалын төв -Мэдээлэл технологийн парк -Инкубатор парк -Ложистик агуулахын аж ахуй <p>Одоогоор ҮТП-ийн хэсэгчилсэн төлөвлөлт хийгдэж байна. Аймгийн үйлдвэрлэл технологийн паркийн мастер төлөвлөгөөг ХХААХҮЯамаар батлуулсан.</p> <p>Үйлдвэр технологийн холимог паркийг Зуунмод хотын 3 бүсэд байгуулах бөгөөд</p> <p>1-р бүс Зуунмод хотын 5-р баг ,</p> <p>2-р бүс Зүүндэлгэр баг,</p> <p>3-р бүсэд Нисэхийн орчим газар байгуулахаар тогтож газрын асуудлыг шийдвэрлээд байна.</p>	
	<p>й)Хүнд үйлдвэрийн паркыг Сэргэлэн сумын нутаг Цагаан хярд байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Сэргэлэн сумын “Цагаан хяр” гэдэг газарт хүнд үйлдвэрийн парк байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж кадастр хийсэн.</p>	
<p><u>Бүтээгдэхүүн 1.1.4:</u> Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого зохицуулалт</p>	<p>а)Эрдэмтэд, газар тариалангийн чиглэлээр дадлага туршлагатай иргэдийг оролцуулж, аймгийн Засаг даргын захирамжаар зөвлөл байгуулж зөвлөлийнүйл ажиллагаа явуулах журмыг боловсруулж батлуулж мөрдөн ажиллана.</p> <p>б) Хаврын тариалалтанд шаардагдах үр, дутагдах техникийн тооцоог хийж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчидийн хуралдаанаар</p>	<p>Засаг даргын дэргэд байгуулах орон тооны бус зөвлөлд оруулах 15 хүний нэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн барьж ИТХ-ын Тэргүүлэгчдийн 28-р тэмдэглэлээр Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлд хандаж Шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэхэд удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Төв аймгийн эрдэмтэдийн зөвлөл байгуулахаар шийдвэрлэн, Төв аймгийн нутгийн зөвлөлд саналаа хүргүүлсэн.</p> <p>Хаврын тариалалтанд дутагдах үрийн тооцоог хийж Аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцэж аймгийн ИТХТ-ийн 2009 оны 04 дүгээр тогтоолоор батлуулав. “Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний зөвлөлд дутагдаж буй үр олгох хүсэлт тавьж шийдвэрлүүлэн,</p>	

	<p>хэлэлцүүлэн шийдвэрийг“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний зөвлөлд хүргүүлнэ.</p>	<p>улсын үрийн нөөцөөс хуваарилсан улаанбуудайн сортын цэвэр үрнээс Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Жаргалант, Эрдэнэсант, Баянцогт, Борнуур, Баянчандмань сумдын 102 аж ахуйн нэгж, иргэдэд 4985 тн үр олгож, 35586 га-д улаанбуудай, Жаргалант, Баянцогт, Аргалант сумдын 3 аж ахуйн нэгж тэжээлийн ургамалын үр үржүүлэх зорилгоор хөх тарианы 13.5тн үр авч 112га-д, Швейцари улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Монголын төмсний салбарыг сэргээн сайжруулах төсөлд Цээл, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянчандмань, Баянцогт, Угтаалцайдам, Зуунмод, Эрдэнэсант сумын 78 аж ахуйн нэгж, иргэд шалгарч өндөр ургац өгдөг Голланд улсын Импала, Санте, Герман улсын Витара, Астила сортын төмсний үрийг, үр ариутгах бодисын хамт олгож 42.5 га-д тариалалт хийсэн. Мөн 19 аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцлөөр дугуйт трактор 8ш, комбайн 11ш, ХАА-н чиргүүл дүүжин машин 8 ширхэгийг тус тус олгуулав.</p>	
	<p>в)Тариаланг дэмжих санг бүрдүүлж тариаланчидад бага хүүтэй зээл олгох ажлыг өргөжүүлнэ.</p>	<p>Аймгийн “Тариалан дэмжих сан”-г бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг боловсруулж Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 14-р хуралдаанд өргөн барьж 7 заалт бүхий журмыг 02 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Хаврын тариалалтыг дэмжих зорилгоор аймгийн тариаланг дэмжих сангаас 11 сумын 159 иргэн, аж ахуйн нэгжид 2.0 тэрбум төгрөгний зээл олгосон зээлийн хүү 53.256.700 төгрөгийг тариалан дэмжих санд төвлөрүүлсэн. Хаврын тариалалтыг дэмжих зорилгоор үрийг 70% хөнгөлж 4985 тн үр олгосоноос гадна уринш боловсруулалтанд 11 сумын 219 аж ахуй иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй 2.0 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.</p>	
	<p>г)Ургамал хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтарч таримал ургамлыг өвчин хортон, хог ургамалын тархалтын зураглал гаргаж, технологийн зөвлөмж боловсруулж, сумдад хүргүүлнэ.</p>	<p>Тариалангийн талбайд тархсан ургамлын өвчин, хортон шавьж, хог ургамал, хөнөөлт мэрэгчдийн тархалтын судалгааг тариалан бүхий 12 сумын 29003.4 га-д УХЭШХ-гээр хийлгэж тэмцэх арга хэмжээний заавар зөвлөмжийн хамт сумдад хүргүүлсэн.</p> <p>Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтарч бэлчээрийн мэрэгчдийн тодотгох судалгааг 21 сумыг хамруулан 4-р сард хийсэн. Судалгаагаар Дэлгэрхаан, Алтанбулаг сумдад тус бүр 50.0 мянган га-д микробиологийн аргаар, Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн сумдад 15000 га-д энгийн механик аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулж тайланг ХХААХҮ-ийн яаманд хүргүүлсэн.</p>	
	<p>д)Үр тарианы үрийн 70-аас доошгүй хувийг ганд тэсвэртэй, дунд богино болцтой, өндөр ургацтай сортын үрээр, төмсний үрийг Голланд улсын өндөр ургац</p>	<p>Улсын үрийг нөөцөөс хувиарласан улаанбуудайн сортын цэвэр үрнээс Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Жаргалант, Эрдэнэсант, Борнуур, Баянцогт, Баянчандмань сумдын 102 аж ахуйн нэгж, иргэд 4985 тн үр авч 35586 га-д улаанбуудай, Жаргалант, Баянцогт, Аргалант сумдын 3 аж ахуйн нэгж тэжээлийн ургамалын үр үржүүлэх зорилгоор хөх тарианы 13.5 тн үр авч 112</p>	

	<p>өгдөг Импала, Санте, Витера сортын үрээр 32-оос доошгүй аж ахуй нэгж, иргэдийг сонгон шалгаруулж үр үржүүлгэд хамруулна.</p>	<p>га-д, Швейцари улсын хөгжлийн агентлагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Монголын төмсний салбарыг сэргээн сайжруулах төсөлд Батсүмбэр, Борнуур, Сүмбэр, Жаргалант, Баянчандмань, Баянцогт, Угтаал, Цээл, Зуунмод, Эрдэнэсант сумдын 78 аж ахуйн нэгж, иргэд сонгогдон, өндөр ургац өгдөг Голланд улсын Импала, Санте, Герман улсын Витара, Астила сортын төмсний үрийг, үр ариутгах бодисын хамт олгож 42.5 га-д тариалалт хийсэн. НҮБ-ын ХХААБ-ын Хүнсний үнийн хөөргөдөлд өртсөн бага орлоготой өрхийн аж ахуйнуудыг дэмжих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 27 сумын 690 өрхөд Голландын санте, Германы астила сортын төмсний 51,7 тн үрийг олгож тариалалт хийж, төмс 28,7 га-гаас 305,6 тн, хүнсний ногоо 34,4 га-аас 327 тн ургац тус тус хураан авсан.</p>	
	<p>е)Хүлэмж, зоорь, жимс, жимсгэний аж ахуйг эрхлэн хөгжүүлэхийг дэмжинэ</p>	<p>27 сумын 56070 мкв талбай бүхий 429 хүлэмжинд 3-5 нэр төрлийн нарийн ногоо тарьж 226,4 тн ургац хураагаад байна. Үүнээс сумдын агропаркуудын 3240 мкв талбай бүхий хүлэмжинд 3-4 нэр төрлийн нарийн ногоо тариалж 11.9 тн ургац хураан авч, 11550 ширхэг үрслэг бойжуулж 6830 ширхэг үрслэгээр иргэдэд үйлчилсэн. Аймгийн хэмжээнд 620 тн-ы багтаамж бүхий 25 зоорь шинээр баригдсан. Одоогийн байдлаар төмс хүнсний ногоо хадгалах 19246 тн-ы багтаамж бүхий 1641 зоорийг ашиглаж байна. Агропарк төслийн шугамаар 27 суманд шинээр баригдах зоорийг 100 % барьж дуусгаж ашиглалтанд хүлээн авсан. Баянчандмань, Баянцогт, Эрдэнэ, Алтанбулаг, Жаргалант, Заамар, Сүмбэр, Батсүмбэр, Угтаалцайдам зэрэг сум чацаргана, үхрийн нүдний 40976 ширхэг суулгацыг шинээр 32.7 га талбайд тарьж бүгд 68.7 га-д жимс, жимсгэний тариалсан нь өнгөрсөн жилийнхээс 90.8 хувиар өсөж 32 тн ургац хураан авсан .</p>	
	<p>ё)Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, экспортод гаргах боломжийг судлана.</p>	<p>Жаргалант суманд “Хаан–Ембүү” ХХК-ны хөрөнгө оруулалттай Европын холбооны стандартыг хангасан өдөрт 5-10 тн сүү боловсруулах хүчин чадалтай “Жаргалан” сүүний үйлдвэр шинээр ашиглалтанд орж нийт 50 гаруй ажлын байр бий болгон сүү, тараг, иогурт, цөцгийн тос зэрэг 5-6 нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн 487 тн–ыг үйлдвэрлэж байна. ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж байгаа “Сүү үйлдвэрлэлийн явцад гарах алдагдлыг багасгах замаар томоохон хотуудын сүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх” төслөөр Баянцогт сумын “Шимт-Уринш” ХХК-нд 5.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өдөрт 300-500 л сүү боловсруулах хүчин чадалтай цех ашиглалтанд оров. Баянхангай, Лүн, Жаргалант сумдын сүү боловсруулах цехүүд 57-120 мян.л сүү ариутган савлаж, 3-4 нэр төрлийн 5-6 тн сүүн бүтээгдэхүүн боловсруулав. Мөн улсын төсвийн 65.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Борнуур, Сүмбэр сумдад 65 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сүү боловсруулах цехүүд, Батсүмбэр суманд 45.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүнсний</p>	

		<p>ногоо боловсруулах цех шинээр байгуулагдав. Эдгээр цехүүд ашиглалтанд орсноор боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ дунджаар 1.4 сая.л болж өмнөх оноос 1350,0 л-ээр, боловсруулсан хүнсний ногооны хэмжээ 2 дахин нэмэгдэв.</p> <p>Зуунмод суманд 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар банш, бууз, гурилан бүтээгдэхүүн боловсруулах цех шинээр ашиглалтанд орж 5 төрлийн хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн 28.6 тн-ыг үйлдвэрлэн сумын хэрэгцээнд нийлүүлэв. Энэ онд бүх сумдыг хүнсний цехтэй болгох зорилт дэвшүүлэн зориулалтын байртай болох, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд хөрөнгө оруулалт шаардлагатай нийт 10 суманд тус бүр 5.0 сая нийт 50 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжив.</p> <p>Чех улсын тусламжаар баригдах махны үйлдвэрийг түшиглэн мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжийг судлана.</p>	
	<p>ж)Мах, сүү, төмс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангана.</p>	<p>Энэ онд хэрэглээний мах 14534 тн, сүү сүүн бүтээгдэхүүн 18.5 сая/л бэлтгэн нийлүүлж байгаа нь өмнөх оноос бэлтгэсэн мах 2000 гаруй тн, сүү 3.0 сая/л-ээр тус тус илүү байна. Мөн үр тариа 44052 га, төмс 3454 га, хүнсний ногоо 1064 га-д тариалалт хийсэн нь 2008 оноос үр тариа 20885 га, төмс 585 га, хүнсний ногоо 151 га-аар тус тус илүү тариалалт хийж, нийт үр тариа 66995 тн, төмс 40068 тн, хүнсний ногоо 10860 тн-ыг тус тус хураан авсан нь нийт хүн амын жилийн хэрэгцээнээс төмс 31868 тн, хүнсний ногоо 3829 тн-оор илүү байна.</p>	
	<p>з)Эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх, тогтоогдсон бүсийн хэмжээнд загвар фермерийн аж ахуй байгуулах бодлого баримтална.</p>	<p>Улсын хэмжээнд фермерийн загвар аж ахуйн шалгуур үзүүлэлт албан ёсоор тогтоогдоогүй байгаа боловч өөрийн аймгийн байгаль, цаг уур, малын үүлдэр омгийн онцлогт тохируулан фермийн аж ахуйн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоолоо.</p> <p>Сүү, махны болон хосолмол ашиг шимт үхрийн үүлдрийн хэв шинжийг хадгалсан, 20-оос доошгүй үнээтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын дагуу баригдсан дулаан байртай, тэжээлийн ургамал тариалалтын зохих хэмжээний талбайтай, ус тэжээлийн хүрэлцээтэй, нэгжээс авах сүү, махны ашиг шим өндөртэй орлогоороо зарлагаа нөхөөд 30.0-аас доошгүй хувийн цэвэр ашигтай ажиллаж байгаа фермийг загвар аж ахуй байхаар тогтоон мөрдөж байна.</p> <p>Сүүний үхрийн 146, махны үхрийн 8, гахайн 36, шувууны 28, туулайн 2, зөгийн 9, мах ноосны хонины 1, нийт 230 фермийн аж ахуйд үхэр 5899, хонь 1200, гахай 1475, шувуу 86624, туулай 62, зөгийн бүл 243 байсан бол 2009 он гарсаар Борнуур, Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант сумдад сүүний үхрийн ферм 4, зөгийн бүл 100-аар нэмэгдэж, үйл ажиллагаа өргөжиж байна.</p> <p>Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл, Лүн сумдад тус бүр нь 15 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар махны чиглэлийн үхрийн аж ахуйн фермийн эхлэл</p>	

		<p>тавьсныг өргөжүүлж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, сайн чанарын үхэр сүргээр сэлбэлт хийх, материаллаг баазаа бэхжүүлэх чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллаж байна. Баянчандмань сумын “Цөм сүрэг үүсгэх” малчны бүлэг нь алтанбулаг, торгууд, үзэмчин үүлдэр, омгийн хуц ашиглан малаа сайжруулсны үр дүнд махны чиглэлийн цөм сүргийн шаардлага хангасан тохиромжтой хэвшлийн 619 толгой хоньтой болсон. 2009 он гарсаар 212 хурганд төрөх үеийн амьдын жин, 260 эм хонины хаврын амьдын жинг үзэж биометрийн боловсруулалт хийлээ. Биометрийн боловсруулалтаас үзэхэд хурганы төрөх үеийн амьдын жин 3.8-4.2 кг байгаа нь монгол хурганаас 0.6-1.2 кг-аар, эм хонины хаврын амьдын жин 40.7-42.6 кг байгаа нь монгол хониноос 2.8-5.0 кг-аар тус тус илүү үзүүлэлттэй байна.</p>	
	<p>и) Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулан хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Мал, амьтадын тэжээлд зориулж Баянчандмань 400.0, Жаргалант 185.0, Эрдэнэсант 57.0, Зуунмод 1.0, Цээл 100.0, Угтаалцайдам 1200.0, Батсүмбэр 1100, нийт 3043.0 тн багсармал тэжээл үйлдвэрлээд байна. Баянцогт сумын Гунын фермд үйл ажиллагаа явуулж байгаа “Зургаан хошуу” ХХК-нь гахайн аж ахуй эрхэлж, энэ онд олон найрлагат тэжээл 3500.0 тн-ийг үйлдвэрлэж, өөрийн хэрэгцээндээ хэрэглэж байна. Мөн Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр сумдын аж ахуйн нэгж, фермерийн аж ахуй эрхлэгчид 459 га-д ногоон тэжээл, Цээл, Сүмбэр сумдад 977 га-д олон наст ургамал, Жаргалант, Баянцогт, Аргалант сумдын 3 аж ахуйн нэгж, фермерүүдэд 112 га-д хөх тариа, нийт 1548 га-д тариалалт хийлээ. Энэ онд байгалийн хадлан 81945.0, гар тэжээл 1107.0 тн, дарш 2250, ногоон тэжээл 3230.0 тн, сүрэл 4105.0 тн-ыг тус тус бэлтгэлээ. Сумд 4318.0 үйлдвэрийн тэжээл гаднаас худалдан авч тэжээлийн хангамжийг нэмэгдүүллээ. Ингэснээр аймгийн хэмжээнд 10861.0 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэж, нөөцөлсөн байна.</p> <p>Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд Баянчандмань, Жаргалант, Цээл, Угтаалцайдам, Эрдэнэсант, Баянцогт, Зуунмод сумдад тэжээлийн үйлдвэр, цех ажиллаж байна.</p>	
	<p>й) Аймгийн хэмжээнд бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт зэрэг тулгамдсан асуудлаар малчид, иргэд, мэргэжлийн зарим байгууллага, мэргэжилтнүүд, нийт 250 гаруй хүнээс санал авч, судалгаа хийв.</p> <p>Аймгийн ИТХ-ын 2009 оны 3-р хуралдааны тогтоолоор батлагдсан “Газрын харилцааны талаар 2009-2012 онд хэрэгжүүлэх бодлого”-д “Бэлчээрийг зохистой ашиглах хамгаалах тухай” 14 заалт, мөн хадлангийн талбайг зохистой ашиглах хамгаалах талаар 5 заалт тусган хэрэгжилтийг зохион байгуулж байна.</p> <p>Аймгийн ИТХТ-ийн 2009 оны 50-р тогтоолоор “Отор нүүдэл хийх, отрын бүс нутгийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн батлуулав. Уг журамд отор нүүдэл хийх, отрын бүс нутгийн үйл ажиллагааг зохицуулах</p>	

		<p>аймгийн Зөвлөлийг Засаг даргаар ахлуулан байгуулж, отрын бүс нутгийн хамгаалалт, ашиглалт, оторчдод үзүүлэх үйлчилгээ, төлбөр хураамж, харуул хамгаалалтын болон оторт очсон малчдын үүрэг, отрын үйл ажиллагааг зохицуулах гэрээ зэрэг 55 үзүүлэлт мөрдөж байна.</p> <p>Тал хээрийн Баянцагаан, Баян-Өнжүүл сумдад НҮБ-ын “Цөлжилтийг бууруулах төсөл”-тэй хамтарч 2 га бэлчээрийг 6 сая төгрөгөөр хадлангийн зориулалтаар хашиж малчдын бүлэгт эзэмшүүлсэн. Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн сумдын багийн ИНХурлын шийдвэрээр өвөлжөө, хаваржааны бэлчээрт тодорхой хугацаанд мал бэлчээхгүй тогтоол гарган ажиллаж байна.</p>	
	<p>к)“Мэргэжилтэй малчин” хөтөлбөр боловсруулж батлуулна.</p>	<p>Төрөөс малчдын талаар баримтлах бодлоготой уялдуулан аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр “Мэргэжилтэй малчин” хөтөлбөрийг 2 үе шаттай боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна.</p>	
<p><u>Бүтээгдэхүүн 1.1.5:</u> Байгаль орчны бодлого, зохицуулалт</p>	<p>а)Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежементийг хэрэгжүүлж ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ байгаль орчны зөрчлүүдийг бууруулах арга хэмжээ авна.</p>	<p>Байгалийн баялагийг хариуцан хамгаалах нөхөрлөлүүдийг Баяндэлгэр, Баянцогт, Эрдэнэ сумдад шинээр 10 нөхөрлөл байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 10 суманд нийт 72 нөхөрлөл үйл ажиллагаагаа явуулж байна. Жаргалант, Батсүмбэр, Мөнгөнморьт сумдад Германы Техник хамтын ажиллагааны нийгэмлэг, Канадын Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент, Монголын байгаль орчныг хамгаалах холбоотой хамтран нөхөрлөлүүдийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 5 удаа сургалт зохион байгуулж, 150 гаруй хүнийг хамруулав. Ойг гэрээгээр эзэмшүүлсэн Жаргалант, Батсүмбэр, Мөнгөнморьт сумдад 25 нөхөрлөл ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж, цаашид ойн талаар хийх үйл ажиллагааны чиглэлтэй болов.</p> <p>Алтанбулаг сумын “Бага цагаан арал” ТББ нь БОАЖГазартай гэрээ байгуулан “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Туул голын Битүүгийн рашаан орчимд 5 га талбайд ойн зурвас байгуулж, 2000 гаруй мод, бут, сөөг тарив.</p> <p>Байгаль орчныг хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сумдад багийн ИНХ-аар хэлэлцүүлэн сум, багт ажиллах идэвхтэн байгаль хамгаалагчийг сонгон ажиллуулж байна. Энэ оны байдлаар 24 суманд 78 идэвхтэн байгаль хамгаалагч томилогдон ажиллаж байна. Шинээр Лүн суманд 1, Өндөрширээт суманд 5, Батсүмбэр суманд 3, Баян-Өнжүүл суманд 3, нийт 12 хүнд үнэмлэх олгож ажиллуулав.</p> <p>Жаргалант, Борнуур, Баянцогт, Батсүмбэр, Мөнгөнморьт сумдад аймгийн МХГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, БОАЖГазар хамтран байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг 3 удаа зохион байгуулж ажиллав. Үүнд: ойн зөрчил 30 гаруйг илрүүлж 235м³ мод хурааж, орон нутгийн орлогод 5,3 сая төгрөг оруулж, 2.5 сая төгрөгний торгууль оногдуулж барагдуулав. Түүнчлэн Жаргалант, Борнуур сумдад гарсан 15 ойн</p>	

		зөрчлийг хэрэг бүртгэлд шилжүүлэв. Жаргалант, Баянцогт сумдад БОАЖГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг ойн хуулийн хэрэгжилтийг шалгаж, зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн 17 хүнд арга хэмжээ авч, 50 шоометр түлшний модыг хураан авч орон нутгийн орлого болгов.	
	б)Уул уурхайн эдэлбэрээс нөхөн сэргээсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	Аймгийн нутаг дэвсгэр дээр уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар хүсэлт ирүүлсэн 22 аж ахуйн нэгж, байгууллагатай 135.25 га талбайд техникийн, 89.33 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсны дагуу 343.2 га талбайд техникийн, 24.9 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан удирдамжийн дагуу ажиллаж, Жаргалант сумын 3, Сүмбэр сумын 3, нийт 6 иргэний 6 ширхэг хууль бус тээрийг хурааж, 3 иргэний тээрэм олдоогүй, 1 тээрийг сумын Засаг дарга, БОХ-ын байцаагчид хурааж авах үүрэг болгосон, Борнуур суманд ажиллаж байсан “ХАМО” ХХК-ын зөрчилтэй байсан учир үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон. Заамар, Сэргэлэн, Угтаал, Жаргалант, Борнуур, Сүмбэр суманд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд аймгийн МХГ, ЦГ, БОАЖГ хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлүүдийг холбогдох арга хэмжээ авсан.	
<u>Бүтээгдэхүүн 1.1.6:</u> Дэд бүтэц хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалт	а)Хот, сум суурин газруудыг хөгжүүлэх ажлын хүрээнд нийгмийн салбарын барилга байгууламжийг шинээр барих засварлах дарааллыг шинэчлэн тогтоож, засварлана.	Нийгмийн салбарын барилгыг шинээр барих, засварлах, өргөтгөл хийх ээлж дарааллыг тогтоох ажлыг Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газар, ГХБХБГазартай хамтран хийж гүйцэтгэн аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХТ-ийн 28 дугаар тогтоолоор батлууллаа. Тогтоосон ээлж дарааллын дагуу 2009 онд аймгийн хэмжээд нийт 9855,1 сая төгрөгийн ажил хийгдлээ. Улсын хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн салбарт халдвартын эмнэлгийн барилга-400.0, Жаргалант сумын хүн эмнэлгийн барилгын засвар-22.0, нэгдсэн эмнэлгийн гражийн засвар-20.0, нэгдсэн эмнэлгийг цахилгааны 2 дахь эх үүсвэрээр хангах ажил-22.0, Зуунмод хотын урлаг спортын цогцолбор-1100, Боловсролын салбарт Эрдэнэ сумын МСС-ийн дотуур байр-472.7, Батсүмбэр сумын сургуулийн өргөтгөл 99.2, Батсүмбэр сумын 100 хүүхдийн цэцэрлэг-361.4, БСГ-ын контор-163.2, Заамар сумын соёлын төв-223.5, Баян сумын соёлын төв-75.0, Алтанбулаг сумын соёлын төв-77.4, Дэлхийн банкны төслөөр Баянжаргалан, Өндөрширээт сумын дотуур байрны засварын ажил хийгдэж дуусаад байна.	
	б)Аймгийн төвд 30 ортой халдвартын эмнэлгийн барилгыг ашиглалтанд оруулна.	Зуунмод хотод баригдаж буй 30 ортой халдвартын эмнэлгийн барилгыг “Аганес Трейд” ХХК гүйцэтгэж барилгын ажлын явцад ГХБХБГ-аас нийт 16 удаа хяналт тавьж ажиллаа. Үүний үр дүнд 30 ортой халдвартын эмнэлгийн	

		барилгын ажлыг гэрээт хугацаанд нь буюу 12 сард ашиглалтанд орууллаа.	
в)Аймгийн төвийн спорт цогцолборыг ашиглалтанд оруулна.		Уг барилгын ажлыг “Үүрэг трейд” ХХК гүйцэтгэж байна. Барилгын суурийн цутгалтын ажил хийгдэж дууссан ба сууриас дээших цутгалтын ажил хийгдэж дууссан. 2 давхрын каркас цутгагдаж байна. Энэ барилга нь Увс аймагт баригдаж буй барилгын зургаар хийгдсэн нэг маягийн зураг төсөвтэй барилга бөгөөд дээвэр, хучилт, дам нуруу нь хийцийн хувьд хүнд, угсрахад төвөгтэй байдлаас шалтгаалан зурганд өөрчлөлт оруулсан. Мөн анх тендер зарлахад гадна, дотор цахилгааны дэд өртөө, тоног төхөөрөмж, сандал, орчны тохижилтын ажлууд орхигдсоныг тодотгож 200,0 сая төгрөгийн ажлыг төсөвт тодотгон оруулж он дамжуулан гүйцэтгэхээр ЭМЯ-наас нэмэлт гэрээ хийгээд байна. Барилгын ажил 50%-тай байна.	
г) Заамар, Баянчандмань сумын халаалтын тогоог шинэчлэн засварлана.		Орон нутгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн шугамаар Заамар, Баянчандмань сумын төвлөрсөн халаалтын тогоог шинэчлэн засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ ажлын хүрээнд эдгээр ажлуудын зураг төсвийг төслийн газар хийж бэлэн болгон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулж тендерийг 4 сард зарласан. Төслийн газраас томилсон Үнэлгээний хороо тендерийн материалыг үнэлж Заамар суманд “АНУ сервис” ХХК, Баянчандмань суманд “Дорнын элч” ХХК шалгарсан. Заамар сумын төвлөрсөн халаалтын тогооны ажлыг 120,0 сая төгрөгөөр, Баянчандмань сумын төвлөрсөн халаалтын тогооны ажлыг 105,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн халаалт эхлэх хугацаанаас өмнө 9 сард ашиглалтанд орууллаа.	
д) Сумдын ЗДТГ-ын автомашиныг шинэчлэх дарааллыг шинэчлэн тогтоож, дарааллын дагуу сумдын ЗДТГ,алба агентлагийн автомашиныг шинэчилнэ.		Баян-Өнжүүл, Борнуур, Баянцагаан сумдын ЗДТГ-ын болон аймгийн ЗДТГ-ын автомашиныг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулж тендерийг сум өөрсдөө зохион байгуулан зарлаж автомашиныг шинэчлэх ажлыг хийлээ.	
е)Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.		Аймгийн хэмжээнд 100000 нарны гэрэл төслийг амжилттай хэрэгжүүлэн, 2008 онд 1648 малчин өрхийг нар салхины үүсгүүрээр хангаж аймгийн хэмжээнд нийт малчин өрхийн 57.3% нь нарны үүсгүүрээр хангагдсан байсан бол 2009 онд шинээр 433 өрх нар салхины үүсгүүртэй болсон байна. Нийт 9689 малчин өрхийн 6791 нь буюу 70% нарны үүсгүүрээр хангагдсан дүнтэй байна. Эрчим хүчний газраас 2010 онд улсын хэмжээнд 20000 өрхийг нарны үүсгүүрээр хангах тендер зарлан гүйцэтгэгчийг шалгаруулж байна. 2010 онд аймгийн 823 өрх нарны үүсгүүр авах захиалгаа хүргүүлээд байна. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, аймгаас өгсөн захиалгын дагуу нарны үүсгүүр нийлүүлсэн талаархи мэдээг улирал бүр ирүүлж байна.	
ж)Хөшгийн хөндийд Олон улсын нисэх онгоцны буудлын дэд бүтэц		Олон улсын нисэх онгоцны буудлыг барихад шаардагдах судалгаа тооцоо, мэдээллээр хангах ажлыг аймгаас зохион байгуулж байна. 2009 оны хувьд	

	барих ажлыг эхлүүлэхэд орон нутгийн оролцоог хангана.	Хөшгийн хөндийн орчмын газар олголттой мэдээллийг гарган өгч тусгай хамгаалалтанд аваад байна. Олон улсын нисэх онгоцны буудлын зураг төсвийг хийж гүйцэтгэх зураг төсвийн компани тендерээр шалгарч зураг төсвийн ажлыг хийж эхлээд байна.	
	з)Шуудангийн үйлчилгээг өргөтгөж, орон нутагт шуудангийн хүргэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч төсвөөс дэмжлэг үзүүлнэ.	Хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүйгээс шуудан хүргэлт тасалдаж байгаа Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Аргалант, Баянцогт, Борнуур зэрэг 6 суманд төсвөөс дэмжлэг үзүүлэн нөхөн төлбөрийн 1890.0 мянган төгрөг олгож дээрхи сумдын шууданг долоо хоногт 2 удаа хүргэх арга хэмжээ авч Сумын Засаг дарга, ТАЗГ, тээвэрлэгч нарын хооронд гурвалсан гэрээг байгууллаа. Тээвэрлэгчтэй гэрээ байгуулснаар дээрхи сумдад 7 хоногт 2 удаа шуудан тогтмол хүргэж ажиллалаа. Засаг даргын нэрэмжит үзлэгийн дүнгээс үзэхэд дээрхи сумдуудад шуудан тасалдаагүй байна.	
	и)Айл, өрх бүрийг интернет хэрэглэгч болгох, малчид гар утас ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.	2009 оны эцсийн байдлаар аймаг дахь үүрэн телефоны Жи-Мобайлын салбар 17 суманд үйлчилгээ үзүүлж, 7000 гаруй хэрэглэгчтэй болсон. Жи-Мобайлын J-10 үйлчилгээний хүрээнд аймгийн хэмжээнд Жи-Мобайл нэвтэрсэн сумдын төрийн албан хаагчдад үнэгүй дугаарыг олгов. Энэ нь яриа хийх, хөдөлгөөнт интернет ашиглах үйлчилгээ юм. Аймгийн холбооны газраас өндөр хурдны ADSL интернет үйлчилгээг Зуунмод сумын хэрэглэгчдэд хүргэж байгаа бөгөөд 2009 онд 200 интернетийн хэрэглэгчтэй болоод байна.	
Бүтээгдэхүүн 1.2.1: Боловсролын бодлого зохицуулалт	а) Сургалт, хүмүүжлийн ажлын уялдаа холбоог сайжруулан бага,суурь,бүрэн дунд боловсролын стандартыг 0.5-1.0% иар ахиулна. б) 6 настай хүүхдийг сургах агуулга, арга зүй, сургалтын орчныг бүрдүүлэн 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулна.	Бага боловсролын эзэмшигчийн төгсөлтийн шалгалтын стандарт 97.12%, АВ-ийн эзлэх хувь 59,90% буюу 0,68%-иар, суурь боловсрол эзэмшигчдийн төгсөлтийн шалгалтын стандарт 99.45%, АВ-ын эзлэх хувь 48.73% буюу 0.4-0.78-иар өсч, бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтын стандарт 98.9%, АВ-ын эзлэх хувь 58.91 буюу өмнөх жилээс 0.4-0.87 хувиар буурч, ЕБС-ийн нийт суралцагчдын стандартын биелэлт 99.65% буюу 3.41%-иар, АВ-ын эзлэх хувь 67.24% буюу өмнөх жилээс 27,04 хувиар өссөн үзүүлэлттэй үнэлэгдсэн байна. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалт, хүмүүжлийн ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр Зуунмод сумын сургуулиудын захирал, сургалтын менежерүүдтэй уулзан, харилцан санаа бодлоо солилцон төлөвлөгөө боловсруулан, сумдын ЕБ-ын сургуулиудад зөвлөмж хүргүүлэв. 30 сургуульд 6 настай хүүхдийг сургах монгол хэл, математикийн үзүүлэн, тогтвортой хөгжлийн боловсрол ном, 6 настай хүүхдийн заах арга зүйн гарын авлагыг хичээл зааж буй 51 багшид, хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх 52.8 сая төгрөгийн бүтээлч сэтгэлгээ, дуу, биеийн тамир, танин мэдэхүйн сургалтын тоглоом сургалтанд ашиглаж байна. Улаанбаатар хотын Багшийн сургуулийн 25 багш, Хүмүүн цогцолбор	

		<p>сургуулийн бага ангийн 36 багш оролцсон “Цэцэрлэг-Бага боловсролын стандарт, агуулгын хүрээний залгамж холбоо, судалгаа” сургалт, семинар зохион байгуулж, бага ангийн бүх багш нарт “6 настай суралцагч” онол арга зүйн 271 номыг тарааж, уншиж судлах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулиудын 1, 2-р ангид хичээл заах 82 багшийн “12 жилийн сургуулийн 1, 2-р ангийн сургалтын агуулга, арга зүй”-н орон нутгийн сургалт зохион байгуулсан. 6 настай 1-р ангийн 1620 хүүхдэд 6 төрлийн 9720 ширхэг сурах бичгийг 1, 2-р ангийн багш нарт хичээл заах 3 төрлийн ном, гарын авлагыг /1.396.200 төгрөгийн/ үнэгүйгээр олгож сургалтанд ашиглаж байна.</p> <p>6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулан сургах ажлын хүрээнд шинэ хичээлийн жилийн зорилтод тусган сургуулийн удирдах ажилтан, бага ангийн багш нарт зөвлөмж, үүрэг даалгавар өгч хамтран ажилласнаар 2009-2010 оны хичээлийн жилд 6 настай хүүхдийн хамрагдалт 82% -тай байна.</p>	
	<p>в)Сурагчдыг “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” хөтөлбөр болгож, шаардагдах стандартуудыг мөрдөж ажиллана.</p>	<p>“Үдийн цай хөтөлбөр”-т ЕБС-ийн 1-5-р ангийн 6834 сурагчийг хамруулан, 519.998 мянган төгрөгийг төсөвлөөд 2009 оны жилийн эцсийн байдлаар 415.998.4 мянган төгрөг хуваарилагдсан.</p> <p>Үдийн цай хөтөлбөрт 2008-2009 оны хичээлийн жилд 1-5-р ангийн нийт ЕБС-ийн 1-5-р ангийн 6834 сурагчийг хамруулан, 1-6 сард 242.428.0 төгрөг зарцуулсан. ЕБС-иуд 7 хоногт 1-5 удаа халуун хоолоор үйлчилсэн. Аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн ИХТ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцүүлж, Засаг даргын 165 дугаар захирамжаар хөтөлбөрийг эрчимжүүлж, хүүхдийн гарын ариун цэврийг сахиулах, эрүүл хүнсээр, цэвэр орчинд үйлчлэх талаар ихээхэн анхаарч ажиллахыг холбогдох байгууллага, удирдах ажилтанд үүрэг болгон хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. 33 сургуулийн “Үдийн цай хөтөлбөр”-т хийсэн хяналт шинжилгээг авч үзэхэд сургуулийн удирдлага 772 удаа, эцэг эхийн зөвлөлөөс 226 удаа, МХГ-аас 38 удаа, сумын ЗДТГ, ИТХ-аас 129 удаа, эмч нар 344 удаа тус тус хяналт хийж, түүний мөрөөр ажил зохион байгуулсны үр дүнд хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. 2009-2010 оны хичээлийн жилд “Үдийн цай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар судалгаа авч үзэхэд одоогийн байдлаар 30 сургуулийн 27 нь орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага гэрээт борлуулагчтай гэрээ байгуулан хүнсний бүтээгдэхүүнээ авч хэрэгцээгээ хангаж, 26 сургууль нь 7 хоногт 1-5 удаа халуун хоолоор үйлчилж, Алтанбулаг сумын сургуульд Тайландын “Гүнжийн сан”-ийн төслөөр “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.</p>	
	<p>г)“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Хүүхэд бүрийг компьютерт суралцах хөдөлгөөн өрнүүлж, бага ангийн сурагчдад компьютер дээр ажиллах чадвар эзэмшүүлэх чиглэлээр “Компьютерийн нөхцөл боломжийн талаарх судалгаа” авахад судалгаа ирүүлсэн ЕБ-ын 30 сургуулийн 7411 хүүхдийн 965 хүүхэд буюу 13.02 хувь нь</p>	

		<p>гэртээ компьютертэй, компьютер дээр ажилладаг чадвартай хүүхэд 2348 буюу 31.8 хувьтай байна. Баянцагаан сумын ЕБС “Хүүхэд бүрт компьютер хөтөлбөр”-ийн хүрээнд 32 ш, Баян сум 123 ш, нийт 155 ш компьютертэй болж тухайн 2 сургуулийн 2-5-р ангийн сурагчид компьютер дээр ажиллах боломж бүрдсэн. Одоогийн байдлаар Бүрэн сумын 11 жилийн сургууль төсөлд хамрагдах саналаа БСШУ-ны яаманд хүргүүлсэн ч боломжгүй байна гэсэн хариу ирсэн.</p> <p>“Хүүхэд бүрт компьютер хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа нэгжтэй холбогдон сургууль бүрт хүүхдийн компьютер /Икс-Өү/ авах тухай санал хүсэлтээ гарган, албан бичиг хүргүүлж, он гараад авч болох тухай зөвлөмж авсан.</p> <p>“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийн хүрээнд компьютерийн ашиглалтын бүртгэл цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан Баян, Баянцагаан сумдын сургуулиудаас Икс-Өү компьютерүүдийн серийн болон бусад бүртгэлийг судалгааны дагуу нарийвчлан авч, анх ирсэн компьютерийн тоотой тохируулан тайланг гаргаж холбогдох газарт нь хүргүүлэв.</p>
	<p>д)Бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэн англи хэлийг мэдээлэл харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгоход байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ</p>	<p>“Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан 2009 оны 63 тоот захирамжаар батлуулан сум, сургуулиудад хүргүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд аймгийн төрийн албан хаагчдын дунд сургалт явуулах сурах бичгийг англи хэлний багш нарын семинарын үеэр сонгон, шалгуурыг боловсруулан, хичээл заах багш суралцагч хоёрын хооронд байгуулах гэрээг боловсруулан сумдад хүргүүлэн хөтөлбөрийн хүрээнд багш, сурагчдын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн, албан хаагчид иргэдийн дунд сургалтуудыг үе шаттай зохион байгуулсан.</p> <p>Сургалтанд ашиглах зорилгоор ном, гарын авлага, үзүүлэн 28543 шинээр авч 531100 төгрөг зарцуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 27 сумдын ЗДТГ, ЕБС, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төвийн ажилтнуудын дунд англи хэлний сургалтын I шатыг 2009 оны эхний хагас жилд “Intercnange -1” сурах бичгийн эхний 4-6 хичээлийг үзэж дуусган мэдээ тайланг ирүүлсэн. Үүнд 20 сумын 802 ажилтан 1195 удаагийн сургалтанд хамрагдсан. Нийт сургалтанд хамрагдагсдаас анхан шатны мэдлэгээр шалгахад гүйцэтгэлийн хувь 67.6% тай дүгнэгдэн, аймаг, сумын ЗДТГ-ын 362 ажилтны гүйцэтгэлийн хувь 62.4, ЕБС-ийнх 72.7%, цэцэрлэгийнх 66.3%, аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлгийн ажилтны гүйцэтгэлийн хувь 72.4%, соёлын төвийн 37 ажилтны гүйцэтгэлийн хувь 59.7 тус тус дүгнэгдсэн.</p> <p>2009 оны жилийн эцсийн байдлаар 27 сумын 120 байгууллагын 1607 ажилтан 1010 цагийн хичээлд хамрагдан 355 ажилтан өөрийн үйл ажиллагаандаа англи хэлийг ашигладаг болсон байна.</p>

		Зуунмод сумын “Хүмүүн” цогцолбор сургууль, Зуунмодны 4, 5-р сургуулиудын 9 багш англи хэлний 4-11 дүгээр ангиудын анги тус бүрийн 5 бүлэг сэдвийн нийт 28 цагийн хичээлийг багцлан, электрон хичээл боловсруулан аймгийн олон нийтийн телевизээр 7 хоногийн даваа гараг бүр 30 минутын сургалтыг 3 удаа явуулав.	
	е)Зуунмод сум дах “Хүүхдийн парк”-ын үйл ажиллагааг тогтмолжуулан, тохижилтыг сайжруулна.	Хүүхдүүдэд үйлчлүүлэх хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг бүрэн хангахад 2.4 сая төгрөгний тохижилтийн засвар хийсэн. Цахилгааны холболтын автоматыг солих, уран жолоодлогот машины дээврийг шинээр засварлан, цахилгааны тусгаарлагч 344 ширхэгийг шинээр хийж сольсон. Цаашид хүүхдүүдэд тоглоомоор үйлчлэхэд хашаажуулах, цахилгааны кабель шугамыг резинэн бүрээстэй утсаар сольж газардуулгыг сайжруулах зэрэг ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.	
<u>Бүтээгдэхүүн 1.2.2:</u> Эрүүл мэнд, нийтийн биеийн тамирын бодлого, зохицуулалт	а)Их спортыг орон нутгийн бүсээр хөгжүүлж, өсвөрийн шигшээ баг хичээллүүлнэ.	Цана, дугуй, хөнгөн атлетик, ширээний теннис, софт теннис, чөлөөт бөх, волейбол, байт харваа, бокс, шатар, даам, үндэсний бөх, тэшүүр, бодибилдинг, гимнастик, сагсан бөмбөг, самбо бөх гэсэн 17 төрлөөр секц дугуйлан хичээллүүлж 3477 хүүхэд, залуучуудыг хамруулав. Олон улс, УАШТ, нэрэмжит тэмцээнд спортын 18 төрлөөр 212 тамирчин оролцсоноос: Алтан медаль -66, мөнгө-51, хүрэл-57, бүгд 174 медаль хүртэж, спортын Дэд мастер-2, Спортын мастерын болзлыг 12 тамирчин хангасан. ААШТ-ийг өсвөр үе, залуучууд 12, насанд хүрэгчид 12, ахмадын 3 төрлөөр зохион явуулж шигшээ тэмцээнд 2697 тамирчин оролцсон. ОУХМ Р.Самбалхүндэв, Х.Хандсүрэн, С.Цэнджав нарын нэрэмжит ААШ өсвөр үеийн волейболын тэмцээнийг Төв аймгийн Дэлгэрхаан суманд зохион явуулж, нийт 12 багийн 139 тамирчин оролцсон. Атар газар эзэмшсэний 50 жилийн ойн хүрээнд “Атарчин залуучуудын спортын наадам”-ыг Угтаал суманд 6-р сарын 13-15-ны өдрүүдэд волейбол, шатар, ширээний теннис, үндэсний бөх, шагайн харвааны төрлөөр зохион байгуулж 11 сумын 13 багийн 238 тамирчин оролцож, багийн нийлбэр дүнгээр Угтаал сумын тамирчид тэргүүн байр эзэлж цом хүртлээ. Өсвөр үеийн шигшээ баг цана, дугуй, хөнгөн атлетик, ширээний теннис, софт теннис, чөлөөт бөх, волейбол, байт харваа, бокс гэсэн спортын 9 төрлөөр 82 тамирчин, 9 дасгалжуулагчтай хичээллэж байна. Өсвөр үеийн шигшээ багийн тамирчид 2009 онд оролцсон олон улс, улс, нэрэмжит тэмцээнээс алт-58, мөнгө-44, хүрэл 53, нийт 155 медаль авсан. Цана Спортын мастер-1, үндэсний сур-2, дугуй-1, хөнгөн атлетик-1 СДМастерын болзол хангасан.	
	б)Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулна	Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор эрүүл мэндийн сургалтанд 51001 хүн, сурталчилгаанд 377923 хүн тус тус хамрагдсан. Орон нутгийн TBS телевизтэй хамтран 56 удаа эрүүл мэндийн мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, “Интернэт хурал”, “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулан, 3440	

		хүнд үйлчилж, 4496 гарын авлага, зөвлөмжийн материал тараан, 1105 хүнд хийн дасгал заасан. Мөн томуугийн А хүрээний N1H1 вирусын халдварын талаарх мэдээлэл, түүнээс урдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, чанга яригч, интернэт ашиглан өдөр бүр албан байгууллага аж ахуйн нэгж, иргэдэд явуулж ажиллаа.	
в)НЭМ-ийн шинжилгээний багажтай болж, шинжилгээ судалгааны ажил хийнэ.		MNS ISO/IEC 17025-2002 сорилтын болон каливровкын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлагын дагуу лаборатори итгэмжлүүлэх өргөдөл, чанарын гарын авлага материалыг боловсруулсан. Лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 700.0 мянган төгрөгийн урвалж бодис, тэжээлт орчин, 10 гаруй нэр төрлийн 106.0 мянган төгрөгийн стандартууд худалдан авч, лабораторийн цахилгааны мантожийг 1.0 сая төгрөгийн зардлаар 380 вольтын хүчдэл, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож, 5 төрлийн багаж, тоног төхөөрөмж шинээр авч, багаж тоног төхөөрөмжийн хангалт 90% хувьд хүрэв. НЭМ-ийн лаборатори нь 473 сорьцонд 1-33 үзүүлэлтээр 3756 үзүүлэлтэнд шинжилгээ хийж, эрүүл ахуйн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран судалгааны баг бүрдүүлж “Усны чанар, орчны эрүүл ахуйн үзүүлэлтүүдийг нян судлалын хурдавчилсан аргаар тодорхойлох арга” сэдэвт сургалтыг сумдын орчны эрүүл мэндийн хөтөлбөрийн зохицуулагч зохион байгуулсан.	
г)НЭМ-ийн чиглэлээр тэргүүний үйл ажиллагаатай аймаг нийслэлээс туршлага судална.		НҮБ-ын ХАС-аас хэрэгжүүлж буй “Эргэлтийн эмийн сан”-гийн төслийн хүрээнд ЭМГ-ын 4 мэргэжилтэн, сумдын 8 эмийн санч, эрхлэгч эмч нар төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа Өвөрхангай, Баянхонгор аймгийн 3 сумын эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаатай танилцав. Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан төвийн бүсийн аймгуудын “Өрхийн эмнэлгийн боловсон хүчний чадавхийг сайжруулах нь” сургалтанд 6 эмч, сувилагч оролцон туршлага судалж, аймгийн НЭ-ийн удирдлага, мэргэжилтнүүд Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан.	
д)Сумдын эмнэлгийг хог хаягдал шатаах зуухтай болгох ажлыг шат дараалан зохион байгуулна		Эрүүл мэндийн сайдын 2009 оны тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах” стратеги батлагдан гарснаар Шинэ менежментеер сумдын эмнэлэгт Хог хаягдал шатаах зуухыг ашиглалтаас хасч, хог хаягдлыг автоклавт ариутган, буталсны дараа устгал хийх технологи нэвтүүлэхээр шийдвэрлэсний дагуу Сумдын эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд Эрдэнэ сумыг загвар сум болгон үзүүлэх сургалт зохион байгуулахаар ЭМЯамнаас 2.5 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн.	
е)НЭМ-ийн лабораторийг магадлан итгэмжлэлд оруулах бэлтгэл ажлыг ханган, шаардагдах багаж тоног		MNS ISO/IEC 17025-2002 сорилтын болон каливровкын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлагын дагуу лаборатори итгэмжлүүлэх өргөдөл, чанарын гарын авлага зэрэг 40 гаруй хуудас материалыг	

	<p>төхөөрөмжийн нэмэгдүүлнэ.</p> <p>хангалтыг</p>	<p>боловсруулсан. Лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 700.0 мянган төгрөгийн урвалж бодис, тэжээлт орчин, 106.0 мянган төгрөгийн 10 гаруй нэр төрлийн стандартууд худалдан авч, лабораторийн цахилгааны мантожийг 1.0 сая төгрөгийн зардлаар 380 вольтын хүчдэлтэй шугам, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож, 5 төрлийн багаж, тоног төхөөрөмж шинээр авч, багаж тоног төхөөрөмжийн хангалт 90% хувьтай болсон. НЭМ-ийн лабораторийг магадлан итгэмжлэлд оруулах саналыг Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвд хүргүүлсэн.</p> <p>Баянчандмань, Угтаалцайдам, Жаргалант сумын эмнэлэг, “Ар жанчивлан” рашаан сувилал, “Тахилт” сэргээн засах төв, “Аксион” хувийн эмнэлэг 2-5 жилээр магадлан итгэмжлэлээ сунгуулсан. Магадлан итгэмжлэгдсэн эмнэлгүүдийн стандартын хангалт дунджаар 87.5 хувь болж 2008 оноос 4.5 хувиар нэмэгдсэн.</p>	
	<p>ё)“Цаасгүй эмнэлэг” төслийг аймгийн нэгдсэн эмнэлэгт хэрэгжүүлэх</p>	<p>“Цахим бүртгэл”-д шилжүүлэх болон “Алсын зайн оношлогооны төв”-ийг байгуулах ажлын хүрээнд АНЭ-ийн 68 компьютероос 55-г дотоод сүлжээнд холбож, шилэн кабелийн үзүүр оруулж, 8 удаагийн сургалтанд 100 ажилтан хамрагдаж, ажиллагсад Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэгт очиж туршлага судлав.</p> <p>Сум, өрхийн эмнэлгүүдтэй хамтран өрх, хүн амын эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдүүлэн, “E-hospital” программаар үйлчлүүлэгчдийн цахим бүртгэлийг үүсгэн үйлчилж байгаа бөгөөд нарийн мэргэжлийн кабинетуудын 44.5% нь сүлжээний горимд ажиллаж байна.</p> <p>Баянхонгор, Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Шастины төв эмнэлэг, Сэргээн засах Клиникийн эмнэлгүүдтэй хамтран өвөл цагийн хичээлийн жилийн нээлт хийсэн. Эрдэнэ сумын эмнэлэг дотоод сүлжээ болон Шастины нэрэмжит III эмнэлэгтэй холбогдож, “Цахим эмнэлэг” төсөлд хамрагдав.</p>	
<p><u>Бүтээгдэхүүн 1.2.3:</u> Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалт</p>	<p>а)Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх болон сумдын эмнэлгүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.</p>	<p>Эрүүл мэндийг газрын хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөн туслах баг 27 суманд 2 удаа ажиллаж, 771 иргэдтэй уулзалт, ярилцага зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг танилцуулан, холбогдох санал хүсэлтийг авсан.</p> <p>Мөн Нийгмийн хөгжлийн хэлтэс, түүний харъяа агентлагууд хамтран өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, барилга байшингийн их засварын ажлыг үнэлж дүгнэсэн. Бүрэн, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Алтанбулаг сумдад архив бичиг хэргийн урьдчилсан үзлэгээр ЭМГ-ын удирдлага, мэргэжилтнүүд ажилласан.</p> <p>Эхийн эндэгдэлийн 3 тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой ЭМГ-ын эмнэлгийн тусламжийн албанаас АНЭ-ийн эх барихын яаралтай тусламж үзүүлсэн мэдээг өдөр тутам авч хяналт тавин ажиллаа. Балнад өвчин гарсантай холбоотой ЭМГ, ХӨСҮТ-ийн холбогдох мэргэжилтэнүүд Өндөрширээт суманд ажиллаж, халдварын эх уурхайг ариутган</p>	

		халдваргүйжүүлж, 100 гаруй хүнээс шинжилгээ авсан. Мөн МХГ-ын үзлэгээр Эрдэнэ суманд эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа доголдолтой гарсан болон халдварт шар өвчин гарсантай холбоотой ЭМГ-ын холбогдох мэргэжилтэн ажиллаж зөвлөн тусласан.	
б)Сумын эмнэлэг бүр лаборанттай болж, лабораторийн анхан шатны стандартыг хангана		26 сумын лаборатори 10 нэр төрлийн багажаар хангагдан 4-12 төрлийн шинжилгээг хийж, шинжилгээний анхан шатны маягыг хөтөлж байна. 6 сумын лаборант төрийн сангийн санхүүжилтээр 10 сарын мэргэжил олгох, 7 лаборант 1 сарын мэргэжил дээшлүүлэх дамжааг дүүргэн, 4 сумын лаборант АНЭ-ийн лабораторийн тасагт дадлагажих сургалтанд тус тус хамрагдаж, сумдын эмнэлгийн 74% нь мэргэшсэн лаборантаар хангагдсан.	
в)Багийн эмч нарыг нормын хувцас, эм, эмнэлгийн хэрэгслэлээр үе шаттай хангах арга хэмжээ авна.		Сумдын 97 багийн 70 эмчийн унаа, нормын хувцас, байрны талаарх дэлгэрэнгүй судалгаа авч, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн өнөөгийн байдлын үнэлгээг 8 суманд хийсэн. Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авахад 3.4 сая, эм эмнэлгийн хэрэгсэлд 76.74 сая, унааны зардалд 400.0 мянган төгрөг зарцуулсан. Багийн эмчийн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлд зарцуулах 5.2 сая төгрөгийг 2010 оны төсвийн төсөлд суулгасан. Дэлхийн зөн ОУБ-ын Төв орон нутгийн хөгжил хөтөлбөрийн санхүүжилт, Эрүүл мэндийн газрын хөрөнгө оруулалтаар 50 багийн бага эмчийг анхан шатны тусламж үйлчилгээний цомог, цүнхээр хангасан.	
г)Магадлан итгэмжлэгдсэн ЭМБайгууллагууд чанарын хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлнэ.		Магадлан итгэмжлэгдсэн 35 эрүүл мэндийн байгууллагын чанарын хөгжлийн хөтөлбөрийг хүлээн авч, хянан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЭМГ-аар батлуулан, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.	
д)Чанар сайжруулах арга зүй болох СОРЕ удирдамжийн болзолыг аймгийн НЭ, өрх, сумд, хувийн хэвшлийн эмнэлгүүд, рашаан сувилалд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ		Эмнэлгийн тусламж үйчилгээний чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх “Чанарын дэвшил-Сэтгэл ханамж” жилийн аяны болзол /СОРЕ/ зарлан, ЭМГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний баг эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж I шатыг дүгнэсэн, эцсийн шалгаруулалтыг 2010 оны 1 дүгээр сард явуулна. ЭМЯ-тай хамтран “Чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт бүсийн сургалтыг АНЭ, сум өрхийн эмч нарт зохион байгуулсан. СОРЕ удирдамжийн сэдвээр АНЭ-ийн эмч, сувилагч нарт ЭМГ-ын эмнэлгийн тусламжийн албанаас сургалт явуулж, тасаг нэгж бүрийн ажлыг дүгнэх үзүүлэлтэд “СОРЕ” үнэлгээний шалгуур үзүүлэлтийг оруулан, үйл ажиллагаандаа СОРЕ үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд ажиллагсад эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах аргыг эзэмшүүлэх сургалтыг батлагдсан хувиарын дагуу 10 удаа зохион байгуулж, 27 суманд “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт үнэлгээ хийж, заавар зөвөлгөө өгсөн. АНЭ-ийн Чанарын албанаас нийт 32 удаагийн дотоодын хяналтыг хийж, 15 зөрчлийг газар дээр	

		нь арилгуулсан ба 5 асуудлыг байгууллагын захиргаанд тавьж шийдвэрлүүлсэн.	
	е)Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн болон сумдын эмнэлэгүүдийн 80-аас доошгүйд ХШҮ хийнэ.	ЭМГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөн туслах баг 27 суманд 2 удаа ажиллаж, 771 иргэдтэй уулзалт ярилцлага зохион байгуулан, иргэдээс гарсан санал, хүсэлтийг тухай бүр нь шийдвэрлэсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, ӨЭН, сумын эмнэлгүүдийн 96.97%-д хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
<u>Бүтээгдэхүүн 1.2.4:</u> Соёл, хүүхэд залуучуудын хөгжлийн бодлого, зохицуулалт	а)Монголын нэрт эрдэмтэн, шог зохиолч, уран барилгач, бурханы шашин, соёлын нэрт зүтгэлтэн Хамба номун хан Агваанхайдавын мэндэлсний 230 жилийн ойг тэмдэглэнэ.	Шашин, соёлын нэрт зүтгэлтэн, яруу найрагч, Монголын философын шинэчлэгч урсгалыг үүсгэгч, Хамбо номун хан Л.Агваанхайдавын мэндэлсний 230 жилийн ойг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ. Ойн хүрээнд “Эрдэм шинжилгээний бага хурал”-ыг 06-р сарын 04-ны өдөр хийж, Монголын бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд, Утга зохиол сонины газар, Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэн, Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн, эрдэм шинжилгээний ахлах ажилтангууд мөн философийн ухааны доктор, профессорууд оролцож, Л.Агваанхайдавын намтар, уран бүтээл, түүний онцлог зэрэг сэдвүүдээр 11 төрлийн илтгэл тавьж, хурал амжилттай боллоо. Эрдэм шинжилгээний бага хурлын материалыг эмхлэн нийт 300 ширхэгийг хэвлүүлж уншигч хэрэглэгчдийн хүртээл болгов. Шашин, соёлын нэрт зүтгэлтэн, яруу найрагч, Монголын философын шинэчлэгч урсгалыг үүсгэгч, Хамбо номун хан Л.Агваанхайдавын мэндэлсний 230 жилийн ойг тохиолдуулан аймгийн нийтийн номын сан өөрийн сан хөмрөгт байгаа бүтээлийн үзэсгэлэн гаргаж уншигч хэрэглэгчдийн хүртээл болгов. Мөн аймгийн музейд Хамбо номун хан Л.Агваанхайдавын хөрөг зургийг залж түүний буланг байгуулан тохижуулсан.	
	б)Сумдын соёл урлагийн өдрийг аймгийн төвд зохион байгуулна.	Дэлгэрхаан, Жаргалант сумд сум сурталчлах “Соёл, урлагийн өдөр”-өө Зуунмод суманд амжилттай зохион байгуулж, сумдын гар урлалын үзэсгэлэн, төмс ногооны худалдаа, “Дөхөмийн уянга”, “Жаргалтай түмний дуулал” нэртэй концертоо Зуунмод сумын иргэдэд толилуулав. Дэлгэрхаан, Жаргалант сумдын Засаг даргын тамгийн газраас сум сурталчлах “Соёл, урлагийн өдөр”-үүдээ Зуунмод суманд амжилттай зохион байгуулсанд талархан БСГ-аас Дэлгэрхаан сумын соёлын төвд 920.0 мянган төгрөгний үндэсний хөгжмийн иж бүрэн зэмсэг, Жаргалант сумын соёлын төвд 920.0 мянган төгрөгний компьютер, принтер олгов.	
<u>Бүтгэдэхүүн 2.1.1:</u> Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, шийдвэр, үүрэг даалгаврын	а)Төр засгийн бодлого шийдвэр, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулж, мэдээллийн технологи ашиглан хэрэгжилт үр дүнг тооцно.	2009 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 89.10%-тай байна. Үүнээс ЗГ-ын тогтоол 88.05%, хуралдааны тэмдэглэл 92.80%, ЗГ-ын албан даалгавар 93.57%, Ерөнхий сайдын захирамж 100%, Шадар сайдын тушаал 100%-ийн хэрэгжилттэй байна. 2009 оны 12 сарын 31-ны байдлаар шинээр нийт 90 шийдвэрийг хяналтанд авч, Засгийн газрын нийт 106 тогтоолын 196 заалт, Засгийн газрын	

<p>хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p>		<p>хуралдааны 24 тэмдэглэлийн 32 заалт, Ерөнхий сайдын 1 захирамж, Шадар сайдын 1 тушаалын 2 заалт, Засгийн газрын 6 албан даалгаварын 29 заалт, нийт 138 шийдвэрийн 260 заалтыг 5 хэлтэс 20 агентлаг, харьяа 5 байгууллагад хяналтын картаар хариуцуулан өгч ажиллав.</p> <p>Тайлант хугацаанд Засгийн газрын 23 тогтоолын 51 заалт, хуралдааны 6 тэмдэглэлийн 9 заалт, Ерөнхий сайдын 2 захирамж, Засгийн газрын 5 албан даалгаварын 27 заалт хэрэгжилт нь бүрэн хангагдаж үйл ажиллагаа нь тогтмолжин 100% хэрэгжсэн тул хяналтаас хаслаа.</p> <p>Аймгийн хэмжээнд 2009 оны байдлаар төрийн захиргааны чиглэлээр 3 хөтөлбөр 83.33%, эрүүл мэндийн салбарт 8 хөтөлбөр 90.0%, боловсрол, соёлын хүрээнд 9 хөтөлбөр 90.0%, хүнс, ХАА-н салбарын 10 хөтөлбөр 90.0%, үйлдвэр дэд бүтцийн хүрээний 18 хөтөлбөр 85.0%, нийгмийн хөгжил, хамгааллын хүрээнд 7 хөтөлбөр 92.0%, байгаль орчин, цаг уур, орчны шинжилгээнд 14 хөтөлбөр 72.14%, хууль зүйн хүрээнд 10 хөтөлбөр 85.56%, нийт 79 үндэсний хөтөлбөр 85.97-тай хэрэгжиж байна. Мөн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хөтөлбөр тус бүрээр нь гарган ЗГХЭГ-т явуулж, аймгийн веб сайтанд тавилаа.</p> <p>Тайлант хугацаанд сумдад хяналтанд авч хэрэгжүүлж байгаа Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг эхний хагас жилд электрон шуудангаар, жилийн эцсийн тайланг цаасан сууриар авч 27 сумыг дүгнэв. Сумын нийт дүнгээр Засгийн газрын 23 тогтоол шийдвэрийн 41 заалтын хэрэгжилт 68.00 хувьтай байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2009 оны эхний хагас жилээс эхлэн сумдаас тайланг авч эхэлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 23 сум тайлан ирүүлж, дунджаар 66.17 хувьтай хэрэгжиж байна.</p> <p>Сумдын “Олон нийтийн интернет мэдээллийн төв”-ийг ашиглан шийдвэрийн хэрэгжилтэнд ХШҮ хийснээр тайлан ирүүлэлт сайжирч, харилцан мэдээлэл солилцоход хугацаа хоцроох явдал багасч, бичиг хэргийн зардал буурах зэрэг ач холбогдолтой байна.</p>	
	<p>б)Нутгийн удирдлагын шийдвэрийн хэрэгжилтэнд Мэдээллийн технологи ашиглан ХШҮ хийж, бодит биелэлтийн үр дүнг тооцож, олон нийтэд сурталчилна.</p>	<p>Төр засгийн болон нутгийн удирдлагын тогтоол шийдвэрүүдийг сурталчилах, таниулах, хэрэгжилтийг зохион байгуулж биелэлт үр дүнд ХШҮ- гээ хийж бодит үр дүнг тооцсон байдалд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгээр шалгаж үнэлгээ дүгнэлт өгч ажилласан ба явцын ХШҮ-гээг 16 суманд хийж шалган туслаж, арга зүйн зөвлөлгөө өгч ажилласан. Мөн Сумдын “Олон нийтийн интернет мэдээллийн төв”-ийг ашиглан сумдад хяналтанд байгаа ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн биелэлтийг сүлжээгээр авч ХШҮ хийсэн нь үр дүнтэй болж, сумдын хагас жилийн тайлан ирүүлэлт сайжирч, хугацаа хоцроох явдал гарсангүй. Аймгийн ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолын биелэлтийг 2009 оны жилийн эцсийн байдлаар авч дүгнэхэд ИТХ-ын 33 тогтоолын 83 заалт</p>	

		<p>90.24 хувьтай, 16 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний 792 залт 82.19 хувьтай, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 81 тогтоолын 205 заалтын хэрэгжилт 83.73 хувьтай, 14 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний 330 заалтын хэрэгжилт 74.91 хувьтай, ИТХ-ын 2009 оны 4 дүгээр улиралд 34 тэмдэглэлийн 79 заалт 94.08 хувийн хэрэгжилттэй тус тус дүгнэгдсэн. Аймгийн ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийн хэрэгжилтэнд ХШҮ-гээ хийсэн дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 01 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулж үнэлгээ дүгнэлт авлаа. Нутгийн удирлагын шийдвэрүүдийн хэрэгжилтийг 2009 оны жилийн эцсийн байдлаар цаасан суурьтай сум, хэлтэс, агентлагуудаас авч салбар бүрээр тооцон гаргаж, хяналт шинжилгээ хийлээ. Нутгийн удирдлагын ХШҮ-ний дүн мэдээллийг жилд 2 удаа аймгийн болон Тамгын газрын Вэбсайтад тавьж, орон нутгийн телвизээр иргэд олон нийтэд сурталчилав.</p>	
	<p>в) Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 27 сум, 97 багийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж сум багийн ажлын түвшинг тогтооно.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын бүтэц зохион байгуулалт, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагуудын чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийн удирдамжийг шинэчлэн боловсруулж 03 дугаар сарын 26-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 148-р захирамжаар батлуулж, хэлтэс агентлагууд болон сумдад интернэизээр дамжуулан хүргүүлэв.</p> <p>Аймгийн Засаг даргын нэрэмжит 1 дэх удаагийн үзлэгийг 06 дугаар сарын 02-10-ны өдрүүдэд 27 сум, 97 багийн хэмжээнд зохион байгуулж дүнг нэгтгэхэд А үнэлгээтэй 4 сум, В үнэлгээтэй 13 сум, С үнэлгээтэй 9 сум, D үнэлгээтэй 1 сум дүгнэгдэж аймгийн дунджаар 82.33 хувьтай, 4.11 оноотой дүгнэгдэж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүнг баталгаажуулж А үнэлгээ авсан Эрдэнэсант, Дэлгэрхаан, Эрдэнэ, Батсүмбэр сумдын Засаг дарга нарыг тус бүр 70.000 төгрөгийн мөнгөн шагналаар урамшуулж, D үнэлгээ авсан Баян сумын Засаг дарга, түүний Тамгын газар төсвийн байгууллагууд, төрийн албан хаагчдад ажлаа сайжруулах, өмнөх үзлэгийн дүнтэй харьцуулахад ажлын амжилт 11.53-14.14 хувиар буурсан болон эзлэх байр 8-12-оор хойшилсон Алтанбулаг, Заамар, Баянцогт, Сүмбэр, Цээл, Угтаалцайдам сумдын Засаг дарга нарт ажил эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын захирамж гарган сумдад хүргүүлээд байна.</p> <p>Аймгийн Засаг даргын нэрэмжит 2 дахь удаагийн үзлэгийн нэгдсэн дүнгээс үзэхэд Үлгэр жишээ буюу "А" үнэлгээг 14 сум, Бүрэн хангалттай буюу "В" үнэлгээг 12 сум, Хангалттай буюу "С" үнэлгээг 1 сум авч, 1 дэх удаагийн үзлэгийн дүнтэй харьцуулж үзэхэд "А" үнэлгээтэй сум 10,-аар нэмэгдэж, "В" үнэлгээтэй сум 1-ээр буурч, "С" үнэлгээтэй сум 8-аар буурч, аймгийн хэмжээнд ажлын амжилт 7.15 хувиар ахиж 89.45 хувьд хүрсэн байна. Сумдаар авч үзвэл Дэлгэрхаан сумаас бусад сумдын ажлын амжилт өмнөх үзлэгийн дүнгээс 0.65-22.6 хувиар ахисан байна. Аймгийн Засаг даргын</p>	

		<p>нэрэмжит үзлэгийн удирдамжийн 65 үзүүлэлтээс Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүрээний “Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах, хэрэгжилтийг зохион байгуулж бодит биелэлтэд мониторинг үнэлгээ хийж ажилласан байдал” үзүүлэлт 79.84 хувьтай “С”, Хөгжлийн бодлогын хэлтсийн хүрээний “Аймаг сумын брэнд бүтээгдэхүүнээр шалгарсан бүтээгдэхүүнийг стандарттай, тохирлын гэрчилгээтэй болгосон байна” үзүүлэлт 78.67 хувьтай “С” үнэлгээг авчээ.</p>	
	<p>г)Засаг даргын нэрэмжит үзлэгийн дүнгээр сүүлийн байруудад орсон сумдад шалган туслах групп ажиллуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.</p>	<p>Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийн дүнг нэгтгэн товхимол болгон гаргаж бүх сумдын удирдлагууд, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүд, зарим агентлагуудад хүргүүлсэн. Үзлэгийн дүн батлах тухай 06 сарын 17-ны өдрийн 296 дугаар захирамжинд ажлаараа хоцорч байгаа болон салбарын чиглэлээр хангалтгүй үнэлгээ авсан сумдад шалган туслах групп ажиллуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхийг нийт хэлтэс агентлагуудад үүрэг болгосон бөгөөд НХХ-ээс үзлэгийн дүн болон цаашид анхаарч ажиллах асуудлын талаар сумдад зөвлөмж хүргүүлэн бүх сумдад нийгмийн салбарын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Бүрэн, Өндөрширээт, Баянхангай, Аргалант, Лүн, Заамар, Цээл, Сүмбэр, Угтаалцайдам, Борнуур, Баянчандмань, Баянцогт сумдад төрийн захиргааны ажил, хяналт шинжилгээ үнэлгээ, шийдвэрийн биелэлт тооцох ажлаар ХШҮ-тасагтай хамтран мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Мөн архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй хамтатган бүх сумдад төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, дотоод ажлын эмх цэгц, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар зөвлөн туслав.</p>	
	<p>д)Зарим сумдад Нэг цэгийн үйлчилгээний танхим бий болгож, төрийн үйлчилгээг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй үзүүлнэ</p>	<p>Угтаалцайдам 7 хүний бүрэлдэхүүнтэй Батсүмбэр, Баян, Мөнгөнморьт сумд 6 хүний бүрэлдэхүүнтэй, Баянцагаан сумд 4 хүний бүрэлдэхүүнтэй Сэргэлэн 5-хүний бүрэлдэхүүнтэй, Эрдэнэ сум бүх мэргэжилтнүүдээ суулган, Борнуур, Баянчандмань, Жаргалант сумд 4 хүний бүрэлдэхүүнтэй, Баянцогт, Зуунмод сумд Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлээд байна.</p>	
<p><u>Бүтээгдэхүүн 3.1.1:</u> Захиргааны удирдлага, зохицуулалт, захиргааны стандартын хангалт</p>	<p>а)Монгол улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, боловсон хүчнийг шилэх, сонгох, томилох, ёс зүйн байдлыг үнэлэх, түвшин тогтоох арга барил нэвтрүүлэн Төрийн жинхэнэ албан хаагч болон Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг зохих журмын дагуу сонгон шалгаруулалт хийж томилно.</p>	<p>Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах болзол журмын дагуу 2009 оны Төрийн албаны мэргэшлийн шалгалт авахтай холбогдуулан 23 сум, байгууллагаас 80 орчим сул ажлын байрны захиалга авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлж нийтэд зарлуулав. Мэргэшлийн шалгалтад 506 иргэн бүртгүүлж орсоноос 108 хүн тэнцсэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэж авлаа. Нөөцөд бүртгэгдсэн иргэдээс төрийн албаны ажлын сул орон тоо гарсан тохиолдолд ажлын байраар ханган ажиллаж байна. Мөн энэ оны 5 дугаар сард авсан төрийн албаны мэргэшлийн шалгалтын үр дүнгээр зарим ажлын байрууд нөхөгдөөгүй үлдсэн тул мөн оны 12 дугаар сард Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг 2 дахь удаа аймгийн төвд зохион байгуулав. Уг шалгалтаар төрийн жинхэнэ албаны 24 сул ажлын</p>	

